premium

Компанийн танилцуулга

Таны бетоны хамтрагч.

Бетон зуурмаг, Сика брэндийн шийдлүүд, хэв хашмал, угаасан элс — аюулгүй ажиллагааны манлайлал, тогтвортой чанар, цаг хугацаандаа нийлүүлэлт, мэргэжлийн хариуцлагатайгаар.

Технологийн түнш Command Alkon®



Олон давхар барилга · Орон сууц · Нисэх буудал · Уул уурхай · Салхины эрчим хүч · Үйлдвэр

Улаанбаатар, Монгол Улс

2026 оны хэвлэл

premiuminnova.mn

Агуулга.

Бид хэн бэ, төсөл хөгжүүлэгчид биднийг яагаад сонгодог, бидний үйлдвэрлэдэг бетон болон үүнийг нотлох төслүүд.

01 · Бидний тухай

Товч танилцуулга 03

Бидний замнал, 2011–2025 04

Бидний үйл ажиллагаа 05

02 · Биднийг сонгох шалтгаан

Премиум 3 амлалт 06

Комманд Алкон технологи 07

Цар хүрээ ба өвлийн нийлүүлэлт 08

Төслийн өртгийг бууруулна 09

03 · Бидний бетон

Бетоны меню 10

Ногоон бетон 11

04 · Төслүүд

Оюу Толгой 12

Нисэх буудал ба Шангри-Ла 13

Салхин паркийн суурь 14

Хотын төслүүд 15

Бидний харилцагчид 16

Холбоо барих 17

Товч танилцуулга

2011 оноос хойш Монголын бетоны хамтрагч.

Премиум Конкрит нь Улаанбаатар хот болон алслагдсан томоохон төслүүдэд бетон зуурмаг үйлдвэрлэн нийлүүлж, Сика брэндийн шийдлүүд, Алю Флекс хучилтын хэв хашмал, угаасан элс нийлүүлдэг. Төсөл хөгжүүлэгчид биднийг аюулгүй ажиллагааны манлайлал, чанар, цаг хугацаандаа хүргэлт, мэргэжлийн хариуцлагын төлөө сонгодог.

6.1

Аюулгүй байдлын хөгжлийн оноо

Рио Тинто, Оюу Толгойн аюулгүй байдлын үнэлгээ

* 2026 оны III улирлын байдлаар

650+

Төсөл хөгжүүлэгч, барилга угсралт, зураг төслийн харилцагчид

1,000+

Иргэний барилга, байгууламж болон дэд бүтцийн төслүүд

4.0M+

Метр куб бетон нийлүүлсэн туршлага

Бидний стандартууд

Баталгаажсан менежментийн тогтолцоо ба түншлэл

ISO 9001

Чанарын менежмент

ISO 45001

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал

ISO 14001

Байгаль орчны менежмент

CSC Хүрэл

Монголын анхны баталгаажсан ногоон бетон

Сика брэндийн албан ёсны дилер

2023 оноос Монгол дахь стратегийн түнш

Бидний замнал

Анхдагч арван таван жил.

Монголын анхны өндөр маркийн болон өвлийн бетоноос эхлээд Комманд Алконы бүрэн автоматжуулалт хүртэл.

2011

Премиум Конкрит байгуулагдав

Монгол Улсын бетон зуурмагийн салбарт чанар, найдвартай байдал, орчин үеийн технологийг нэвтрүүлэв.

2013

Олон давхар барилгад өндөр маркийн бетон

С40, С45 бүтэцийн маркийг нэвтрүүлж, том хэмжээгээр нийлүүлэгч Монголын анхны компаниудын нэг болов.

2013

Өвлийн бетоны технологийг түүчээлэв

Хүйтэн цаг уурын нөхцөлд бетон нийлүүлэх технологийг анх нэвтрүүлж, өвлийн улиралд ч барилга угсрах боломжийг бүрдүүлэв.

2017

Оюу Толгойн нийлүүлэгч

Дэлхийн хамгийн том зэс, алтны уурхайнуудын нэгийн цор ганц бетон зуурмаг нийлүүлэгч.

2017–2023

ТОП-100 компани, дөрвөн удаа

2017, 2018, 2020, 2023 онд Монголын шилдэг 100 компанийн жагсаалтад нэрлэгдэв.

2020

Аюулгүй ажиллагаагаар шалгарав

Рио Тинтогийн Гүйцэтгэх захирлын аюулгүй ажиллагааны шагнал; Оюу Толгойн Шилдгийн Шилдэг Нийлүүлэгч, Хамгийн Шилдэг Аюулгүй Ажиллагааны шагнал.

2023

Сика брэндийн албан ёсны дилер

Сика брэндтэй стратегийн түншлэл: ус тусгаарлалт, нэмэлт бодис, шал, бүтээцийн засвар.

2025

Алю Флекс хучилтын хэв хашмал

Угсрахад хурдан, задлахад хялбар, барилгын мөчлөгийг богиносгодог хөнгөн цагаан хэв хашмал.

2025

Анхны CSC ногоон бетон

Тогтвортой Бетоны Зөвлөлийн (CSC) Хүрэл гэрчилгээг авсан Монголын анхны компани.

2025

Комманд Алкон автоматжуулалт

Бодит цагийн үйлдвэрлэлийн хяналт, хүргэлтийн менежментээр дэлхийн тэргүүлэгч үйлдвэрлэгчдийн эгнээнд нэгдэв.

Бидний үйл ажиллагаа

Бетон, Сика бүтээгдэхүүнүүд, Хэв хашмал.

Цогц шийдлүүд


Бетон зуурмаг · Улаанбаатар

Баталгаат, тасралтгүй бетон нийлүүлэлт.

✓ Үйлдвэрлэлээс цутгалт — бүрэн автоматжуулсан

✓ Талбай дээр чанарын эрсдэлгүй

✓ Цаг тухай бүрийн дата, мэдээлэл




Технологийн түнш Command Alkon



Алслагдсан төслүүд

Талбайн үйлдвэр ба V-Truck


Таны талбай дээр үйлдвэр байгуулж ажиллуулна, эсвэл V-Truck: нэг ачилтад 8,5 м³, цагт ойролцоогоор 50 м³.



Сика шийдлүүд · албан ёсны дилер

Ус тусгаарлалт, засвар, нэмэлт бодис

Барилгын химийн материалаар дэлхийд тэргүүлэгч Швейцарын брэндийн цогц системүүд.



Алю Флекс хучилтын хэв хашмал

Угсралт 3 дахин хурдан, материал 80% бага

Хавтанг эрт задалж, тулгуурууд хучилтыг 28 хоног даана.



Угаасан элс ба хайрга

Өөрсдийн элс угаах үйлдвэрлэл

Гуравдагч талаас хараат бус — 1%-иас бага тоос, шавартай хамгийн цэвэр элс.

Премиум 3 амлалт

Ачилт бүрийн төлөө хариуцлагатай.

Үйлдвэрлэл, үйлчилгээний чанараа санхүүгийн хариуцлагаар баталгаажуулдаг Монголын цорын ганц бетон нийлүүлэгч. Таны төсөл зогсохгүй байхаар бид ажилладаг — хэрэв алдвал бид төлнө.

01 Хоцролтгүй хүргэлт

Нөхцөл

Захиалгын эхний миксер тохирсон цагаас хойш 30 минутын дотор таны талбайд ирээгүй бол.

Нөхөн олговор

2М₮

2 сая төгрөгийн бетон зуурмагийн эрхийн бичиг

02 Баталгаат чанар

Нөхцөл

Цутгасан бүтээцэд бидний үйлдвэрлэл, үйлчилгээнээс хамааралтайгаар согог үүссэн нөхцөлд.

Нөхөн олговор

100%

Сика брэндийн бетон засварын бүтээгдэхүүний зардлыг хариуцна

03 Тоо хэмжээний нарийвчлал

Нөхцөл

Хүргэсэн тоо хэмжээ захиалгаас дутах буюу илүү гарсан тохиолдолд.

Нөхөн олговор

200×

дахин нөхөж, бетон зуурмагийн эрхийн бичиг олгоно

Та өөрөө хянана

Ачилт бүрийн чанар, цаг хугацаа, тоо хэмжээг Комманд Алкон системээр цаг тухай бүрд нь хянан, баримтжуулна.

Асуудал гарвал нөхөн олговортой

Нийлүүлэгчээс үүдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын асуудал гарсан нөхцөлд бид дээрх нөхөн олговрыг олгоно.

Хамрах хүрээ: Улаанбаатар хот доторх төв үйлдвэрүүдээс хийгдэх нийлүүлэлтэд хамаарна. Алслагдсан төсөл, талбай дээрх үйлчилгээний нөхцөлийг гэрээгээр тусад нь тохирно.


Технологийн түнш Command Alkon®

Алдаагүй, нэмэлт зардалгүй.

Комманд Алкон нь бетон үйлдвэрлэл, чанар хяналт, логистикийг нэг автомат системд нэгтгэдэг. Алхам бүрийг удирдаж, хэмжиж, бүртгэдэг тул нийлүүлэлт хүний алдаагүй бөгөөд та бүхнийг цаг тухай бүрд нь харна.

15,000+

тэргүүлэгч үйлдвэрлэгч дэлхий даяар ижил системээр ажилладаг




Шуурхай захиалга

1 · Харилцагч

Захиалга

Апп-д марк, хэмжээ, цагаа оруулна — хүргэлтийн цаг шууд баталгаажна.




Урьдчилан харах

2 · Премиум

Хуваарилалт

Хүчин чадал, зай, замын нөхцөлөөр тохирох үйлдвэр, миксерт хуваарилна.



Тоо хэмжээний баталгаа

3 · Премиум

Үйлдвэрлэл ба хяналт

Орц бүрийг граммын нарийвчлалтай жинлэж, ачилт бүрийг бүртгэнэ.




Цаг тухай бүрийн хяналт

4 · Премиум

Хүргэлт ба хяналт

GPS, ETA-г шууд харна; барабаны мэдрэгч суулт, температурыг хянана.



Бүрэн баримтжуулалт

5 · Харилцагч

Хүлээн авч, баталгаажуулах

Ачилт бүрийн цахим тасалбар, бүртгэл “Cloud”-д хадгалагдана.

Асуудал замд шийдэгдэнэ

Чанарын зөрчлийг цутгахаас өмнө илрүүлж, шаардлагатай бол ачилтыг солино. Танай талбайд зөвхөн шаардлага хангасан бетон, яг цагтаа очно.

Урьдчилан харж, илүү сайн төлөвлө

Саатлыг урьдчилан харж, ажиллах хүч, техникээ цаг алдалгүй уян хатан зохицуулна.

Бүх багт нэг эх сурвалж

Инженерт чанарын үзүүлэлт, худалдан авалтад гэрээний гүйцэтгэл, санхүүд тооцоо тулгалтын баримт.

Цар хүрээ

Тасралтгүй нийлүүлэлт.

Зуны оргил ачааллаас өвлийн хүйтэн хүртэл бид давчуу талбай, хотын түгжрэл, алслагдсан байршлыг даван нийлүүлэлтийг тасалдуулахгүй.

01

Байршил ба хамрах хүрээ

Улаанбаатар даяарх гурван төв үйлдвэр

Хотын аль ч төсөлд хамгийн ойр, хурдан хүрэхээр байршсан.

Бие биенээ нөхдөг үйлдвэрүүд

Нэг үйлдвэр зогсвол дараагийнх нь ачааллыг автоматаар авна. Том цутгалтад гурвуулаа зэрэг ажиллана.

Талбайн үйлдвэр ба V-Truck

Түгжрэл, цагийн хязгаарлалтаас хараат бус талбайн үйлдвэр, эсвэл 1 м³-ээс эхлэн зуурдаг V-Truck.

02

Тогтвортой түүхий эдийн эх үүсвэр

Цементийн стратегийн түншлэл

Тэргүүлэгч цемент үйлдвэрлэгчидтэй хамтарч, өөрийн нөөцийг оргил улиралд ч бэлэн байлгадаг.

Өөрсдийн элс угаах үйлдвэрлэл

Гуравдагч талуудаас хараат бус — 1%-иас бага тоос, шаврын агууламжтай хамгийн цэвэр элс.

Сика нэмэлт бодисыг өөрсдөө хангана

Бид Сика брэндийн дилерийн хүрээнд өөрсдийн химийн нэмэлтийг ханган ажилладаг.

A TRUSTED PARTNER OF Sika

03

Хүйтэн цаг уурын нөхцөлийн нийлүүлэлт

Барилгын улирлыг уртасгана

80–120+ хоног

Халаалттай, дулаалгатай үйлдвэрүүд

Цаг агаараас үл хамааран жилийн турш үйлдвэрлэнэ.

Polarmatic систем



Ус, дүүргэгчийн температурыг автоматаар удирддаг Финландын технологи.

Цахилгааны нөөцийн генераторууд



Гэнэтийн тасалдалд ч үйлдвэрлэл хэвийн үргэлжилнэ.





Төслийн өртөг

Төслийн өртгийг бууруулна.

Хамгийн хямд үйлчилгээ гэдэг нь гэрээний үнээсээ давдаггүй, төслийн нийт төсвийг нэмэгдүүлдэггүй үйлчилгээ юм.

Нэгж үнэ
Гэрээний дүн

+

Далд эрсдэл, зардал
Хоцролт, эвдрэл, засвар

=

Төслийн нийт өртөг
Таны бодит төлбөр

Нэгж үнэ бол зөвхөн эхлэлийн тоо. Бодит зардал хаанаас үүсдэг вэ — бид үүнийг хэрхэн хаадаг вэ:

01

Хүргэлт хоцрох, үйлдвэрлэл тасалдах — талбайн сул зогсолт

Бригад, помп, кран сул зогсоно. Ажлын явц ахихгүй ч цалин, түрээсийн зардал үргэлжилнэ.

Юугаар хаадаг вэ

- ✓ Хотыг бүрэн хамарсан 3 үйлдвэр
- ✓ Бие биенээ нөхдөг үйлдвэрүүд
- ✓ Cloud Dispatch ба шууд ETA
- ✓ Амлалт 01 — хоцорвол 2 сая ₮

02

Шаардлага хангахгүй бетон — ачилт буцаагдах

Дараагийн ачилт иртэл цутгалт зогсоно. Согог алдагдвал дахин хийх, засварлах ажил дагана.

Юугаар хаадаг вэ

- ✓ Лабораторид баталгаажсан орц, граммын нарийвчлалтай
- ✓ Барабаны мэдрэгч ачилт бүрийг замд нь хянана
- ✓ Угаасан элс ба Сика нэмэлт бодис
- ✓ Амлалт 02 — засварын бүтээгдэхүүн 100%

03

Тоо хэмжээ, нэхэмжлэлийн маргаан

Захиалсан, хүргэсэн, нэхэмжилсэн хэмжээг тулгахад алдсан цаг — түүнээс үүдэх маргаан.

Юугаар хаадаг вэ

- ✓ Ачилт бүрийн бодит жин, хэмжээ
- ✓ Цахим тасалбар ба хүргэлтийн баримт
- ✓ Бүрэн түүх, нэг бодит эх сурвалж
- ✓ Амлалт 03 — зөрүүг 200 дахин

Бетоны меню

Бүтээц бүрт зөв бетон.

Шал, багана, суурь, шигүү арматурчлалтай бүтээц гээд хэрэглээ бүрт зөв бетон сонгох нь ажлын ачааллыг бууруулж, төслийн зардлыг хэмнэнэ.

C10 – C100 Бүх төрлийн анги, марк

±800 мм ажиллах чадвар, ямар ч цутгалтад тохируулна

Sika брэндийн химийн нэмэлтүүд

1 Стандарт бүтээгдэхүүн 4

Техникийн онцгой нөхцөл шаардахгүй. Ихэнх орон сууц, барилга байгууламжид ашиглагддаг.

- **Ус тусгаарлагч бетон** — W12 усны даралт тэсвэрлэх
- **Масс бетон** — Дулаан ялгаралтыг хянана
- **Шалны бетон** — Өнгөлгөө, тэгшилгээнд хялбар
- **Өвлийн бетон** — Жилийн 4 улиралд барилга угсралт

2 Тусгай бүтээгдэхүүн 6

Төслийн онцгой техникийн шаардлагад зориулсан. Энгийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад нэмэлт үйлчлэл шаарддаг.

- **Файбер бетон** — Агуулах ба үйлдвэрийн шал
- **Агаарын агууламжтай бетон** — Хөлдөөлт, гэсгээлтэд тэсвэртэй
- **Эхэн үеийн бат бэх өндөр бетон** — 3 хоногт 70% бэхжилт
- **Удаашруулагчтай бетон** — Бэхжих хугацааг уртасгана
- **Өөрөө нягтардаг бетон** — Бетон тараах бригад болон вибратор шаардлагагүй
- **Шүршдэг бетон** — Туннель ба налууг бэхжүүлэх

Захиалгат орц, найрлага. Харилцагчтай хамтран төслийн онцгой хэрэгцээ, шаардлагад тулгуурлан боловсруулна.

Ногоон үйлчилгээ

Монголын анхны ногоон бетон.

Бат бэх, ашиглалтын үзүүлэлтээ хадгалан CO_2 ялгаруулалт, ус, эрчим хүчний хэрэглээг системтэйгээр бууруулдаг бетон. Барилгын материалын тогтвортой үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдлыг баталгаажуулдаг Европт төвтэй олон улсын байгууллага — Тогтвортой Бетоны Зөвлөлийн (CSC) Хүрэл гэрчилгээтэй.

↓ CO_2 ялгаруулалт **↓ Усны хэрэглээ** **↓ Эрчим хүчний ашиглалт**



Премиум Конкрит олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн энэ стандартыг хангасан Монголын анхны компани болов.

Таны төсөлд өгөх үр өгөөж

01

Ногоон барилгын стандартад нийцнэ

LEED · BREEAM · EDGE гэрчилгээжүүлэлтийн шаардлагад тохирно.

02

Ногоон санхүүжилтийн боломжийг нээнэ

Ногоон зээл, хөнгөлөлттэй санхүүжилтийн шалгуурыг хангахад тусална.

03

Төслийн ногоон үнэлгээг өсгөнө

Барилгын тогтвортой байдлын үнэлгээнд шууд оноо нэмнэ.

Тэргүүлэх төсөл · Уул уурхай · 2017 оноос

Оюу Толгой.

Дэлхийн хамгийн том зэс, алтны уурхайнуудын нэгд бетон үйлдвэрлэл, нийлүүлэлтийн цогц үйлчилгээ.

2017 оноос хойш бид төслийн газрын дээрх болон далд бүтээн байгуулалтад бетон зуурмагийн иж бүрэн, аюулгүй, тасралтгүй үйлдвэрлэл, нийлүүлэлтийг хангаж, аюулгүй ажиллагаагаар тэргүүлэн ажиллаж байна.



1M+ m³
Нийт нийлүүлсэн бетоны хэмжээ

2M+
Хөдөлмөрийн чадвар алдсан аюул осолгүй хүн цаг (2022 он, хамгийн өндөр үзүүлэлт)

6.1
Аюулгүй ажиллагааны соёлын түвшин, Рио Тинтогийн үнэлгээ (2026 оны II улирал)

236
Төсөл дээрх ажиллагсад

RioTinto Oyu Tolgoi

Шагнал, 2020

✓ Рио Тинтогийн Гүйцэтгэх захирлын аюулгүй ажиллагааны шагнал

✓ Оюу Толгойн Шилдгийн Шилдэг Нийлүүлэгч

✓ Хамгийн Шилдэг Аюулгүй Ажиллагааны шагнал



Нисэх буудал · 2013–2016

Шинэ олон улсын нисэх буудал.

Талбай дээрх дөрвөн үйлдвэр жилд 3 сая зорчигч үйлчлэх терминал, 3,600 метрийн хөөрөх зурвас зэрэг бүх ажлыг тасралтгүй хангасан.

260,000+
м³ бетон нийлүүлсэн

4
талбайн үйлдвэр, төслийн турш

3,600 m
хөөрөх зурвас, зогсоол болон CSB суурь үе

Ерөнхий гүйцэтгэгч: Mitsubishi & Chiyoda түншлэл

Барилга угсралтын гүйцэтгэгч: Samsung C&T

Санхүүжилт: Монгол Улсын Засгийн газар, JICA-ийн хөнгөлөлттэй зээл



Худалдаа, орон сууц

Шангри-Ла Худалдааны Төв, Орон Сууц.

5 одтой зочид буудал, 35 давхар цамхаг, орон сууц, худалдааны төв — олон улсын стандартын C40, C45 бетоноор баригдсан Монголын анхны төсөл, 4 улирал тасралтгүй нийлүүлсэн.

41,000+
м³ бетон нийлүүлсэн

C40 · C45
өндөр маркийн бетон, ийм хэмжээнд анх удаа

4 улирал
хүйтэн уур амьсгалд масс цутгалт

Ерөнхий гүйцэтгэгч: Samsung C&T

Санхүүжилт: М-Си-Эс Холдинг ба Шангри-Ла Азиа

Сэргээгдэх эрчим хүч · Алслагдсан талбай

Салхит · Цэций · Сайншанд.

Улаанбаатараас алслагдсан гурван салхин паркийн 80 гаруй турбины сууринд өндөр маркийн бетон нийлүүлсэн. Суурь бүр байнга өөрчлөгдөх салхины ачааллын эсрэг хэдэн зуун тонн бүтээцийг тогтоож, цамхаг босгосны дараа засах боломжгүй тул олон арван жил чанараа хадгалах ёстой.



80+
турбины суурь

3
алслагдсан талбай, найдвартай логистик

Сорилт: чичиргээний ядаргаа


Турбины суурь эргэх далавчаас үүдэх сая сая бичил чичиргээг жилээс жилд даадаг. Орц бүрийг зуны халуунаас −40°C-ийн өвөл хүртэл давтамжит ачаалалд удаан тэсвэрлэхээр боловсруулсан.

Төсөл	Хөгжүүлэгч	Санхүүжүүлэгчид
Салхит салхин парк	Leighton	Newcom Group, General Electric
Цэций салхин цахилгаан станц	Clean Energy Asia	Newcom Group, SoftBank Energy
Сайншанд салхин парк	CMEC	ENGIE, Ferrostaal, DCIF, EIB, EBRD

Хотын төслүүд · Улаанбаатар

Давчуу талбайд том цутгалт.

Хязгаарлагдмал цаг, хумигдмал орц гарц, дуу чимээний хязгаарлалтыг талбайн үйлдвэр, нарийн зохицуулалтаар шийдсэн.




ЭКО Тауэр

7,500 м³

60 цагт, нэг тасралтгүй цутгалт

Монгол Улсын хамгийн өндөр барилга. Суурь нь өвлийн улиралд, хотын төвд 60 цаг тасралтгүй цутгасан улсын хамгийн том нэг удаагийн цутгалт.




Энканто Худалдааны Төв

10,100 м³

3 суурь, дунджаар тус бүр 16.6 цаг

Монголын орчин үеийн барилгын түүхэн дэх хамгийн хурдан суурийн цутгалт — 100 гаруй техникийг зэрэг удирдсан.



Энканто Центро Худалдааны Төв

6 блок

2.5 жил зэрэг нийлүүлсэн

Зориулалтын талбайн үйлдвэр зургаан блокийг тасралтгүй хангаж, суурь, зоорийг SikaProof-оор ус тусгаарласан.



М-Си-Эс Тауэр

10%

талбайн хэсгийг манай үйлдвэр эзэлсэн

Хатуу цагийн хуваарь, давчуу орц, дуу чимээний хязгаарлалтыг бага дуу чимээтэй авсаархан үйлдвэр, тасралтгүй үйлдвэрлэлээр шийдсэн.

Бидний харилцагчид

650+ харилцагчийн итгэл.

Премиум Конкриттэй хамтран бүтээн байгуулдаг олон улсын төслийн эзэд, хөгжүүлэгчид, гүйцэтгэгчид.

RioTinto

Oyu Tolgoi

SAMSUNG C&T

CMEC

MCS property

MONCON CONSTRUCTION

MAK

CAMDER

ИНЭЛ

АКД КОНСТРАКШН

ТАВАН БОГД ГРУПП
Хамтын хүч - Амжилтын түлхүүр

NCD GROUP
НОГООН ИРЭЭДҮЙГ БҮТЭЭНЭ

JIGUUR GRAND GROUP

ХУРД ГРУПП

STEPPE ARENA

MSM

STRONGER LLC CONSTRUCTION

ДЭЛГЭРЭХ ТАВАН ЧАНДМАНЬ ХХК

MAGNUS CENTURION CONSTRUCTION

630+
бусад харилцагч

Таны бетоны хамтрагч 2011 оноос.

PREMIUM
Concrete

Холбоо барих

Зөвлөгөө, үнийн санал.

Төслийнхөө талаар бидэнд хэлээрэй — бид орц, үйлдвэр, хүргэлтийн төлөвлөгөөг тань тохируулна.

Борлуулалт

+976 7777 3311

Имэйл

info@premiuminnova.mn

Вэбсайт

premiuminnova.mn

Оффис

Олимпын гудамж 19А, Шангри-Ла оффис, 23 давхар,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14241, Монгол Улс

Технологийн түнш Command Alkon®